

Ёс зүйн дүрэм

Энэхүү дүрмийн үндсэн зорилго нь: ГМБЭХ-ны үйл ажиллагаа, гишүүдийн үр бүтээлтэй, үр ашигтай, зохистой, тогтвортой хөгжлийг хангахад орших бөгөөд холбооны гишүүд болон удирдах зөвлөлийн гишүүд, санхүүгийн хяналтын гишүүд нь энэ дүрмийн үндсэн зарчимыг даган, үүний агуулга мөн чанарыг өдөр дутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болговол зохино.

Хууль, дүрэм мөрдлөгө болгох:

Хуульд нийцүүлэх

ГМБЭХ нь үйл ажиллагаандаа Герман болон Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль дүрэмийг мөрдөх бөгөөд улмаар өөрийн ажилтан, гишүүдтэйгээ хуулийн хүрээнд харьцах үүрэгтэй. Хэрэв гишүүн ажилтан холбогдох этгээд ямар нэгэн эрүүгийн хариуцлага хүлээсэн үйлдэлтэй бол харилцахыг хориглох бөгөөд энэ нь холбооны нэр хүндэд сөргөөр нөлөөлнө гэж үзнэ. Нээлттэй ажлын байранд хүсэлт гаргагч, гишүүнийн сонгуульд нэр дэвшигч нь өөрийхөө тухай бичгээр тайлбар гаргана. Шаардлагатай гэж үзвэл удирдах зөвлөл албан ёсны нотлох баримт шаардаж болно.

Дүрэмд нийцүүлэх

Холбооны ажлын үндэс нь ГМБЭХ-ны дүрэмд заасан зорилго зорилт, холбооны институцуудын /гишүүдийн хурал, удирдах зөвлөл, удирдах зөвлөлийн дарга, санхүүгийн хяналтын гишүүн, гүйцэтгэх захирал, түүний алба/ үүрэг даалгавар, холбооны хүлээх хариуцлага, зохицуулалтууд болно. Ажилтан албан хаагчид, гишүүд ёс зүйн дүрэмийг баримтлах үүрэгтэй. Анх удаа дүрэм зөрчсөн бол бичгээр сануулах бөгөөд давтан үйлдсэн тохиолдолд хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгоно.

Хүний эрх:

Бие даасан байдал, тэгш эрх

ГМБЭХ нь 2 талын хамтын ажиллагааны байгууллага тул хамтран ажиллагсадын олон талын хамтын ажиллагаа, мэдлэг чадвар, авьяас билэгт тулгуурлана. Энэхүү өргөн дэлгэр мэдлэг чадвар, авьяас билэг нь хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх урьдчилсан нөхцөл болно. ГМБЭХ нь шашин шүтлэг, итгэл үнэмшил, арьс өнгө, нас хүйс, гарал үүсэл, иргэншил, гэр бүлийн байдал, биеийн болон сэтгэцийн саатал, билгийн чиг баримжаа зэргээр ялгаварлан гадуурхахгүй байх зарчмийг баримтлах бөгөөд хувь хүний нэр хүндийг хүндэтгэнэ.

Бэлгийн дарамтаас хамгаалах

ГМБЭХ нь ажилтныхаа өмнө хариуцлага хүлээх ба тэднийг хохирол учруулахуйц үйлдлээс хамгаална. Өөрөөр хэлбэл аюулгүй орчинд ажиллах орчныг бүрдүүлж бэлгийн дарамт энэ төрлийн халдлагаас хамгаалах үүрэгтэй. Хэрэв энэ төрлийн үйлдэл илэрвэл удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагад мэдэгдэнэ. Холбооны зүгээс хамгаалах арга хэмжээг шууд авна.

Насанд хүрээгүй хүүхдийг хөдөлмөр эрхлүүлэхээс зайлсхийх

ГМБЭХ нь насанд хүрээгүй хүүхэдээр хөдөлмөр эрхлүүлэхгүй бөгөөд тэднийг хамгаалан сурах боловсрох эрхээр хангана. Насанд хүрээгүй хүүхдийг аливаа ажил хийлгэхийг хориглоно.

Бизнесийн ёс зүй:

Шудрага байдал

Холбооны гишүүд, удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх албаны ажилтнууд нь ажил үүргээ үнэнч шудрага, нэр төртэй гүйцэтгэнэ.

Бизнесийн зөвлөгөө

Холбоонд хандан хувь хүн, үйлчлүүлэгчид, бизнесийн хамтрагчид зөвлөгөө дэмжлэгээ авах санал тавьсан тохиолдолд холбооны гүйцэтгэх албанаас зүгээс өөрийн байгууллагын мэргэжлийн чадвар, бүх талын сүлжээгээ ашиглан судлаж, үйлчлэх болно.

Сонирхолын зөрчил:

Үнэнч шудрага байдал

Холбооны удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх алба нь өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд гишүүд болон холбооны эрх ашгийг үүднээс үйл ажиллагаа явуулна.

Байгууллагын санхүү, харилцагчид үзүүлж буй үйлчилгээ болон бусад итгэл хүлээлгэсэн мэдээллийг гуравдагч этгээдэд ашигтай байдлаар дамжуулж, хувийн ашиг сонирхолоор хандахыг хориглоно.

Үйл ажиллагааны хуваарилалт

ГМБЭХ-ны дүрэмд зааснаар гүйцэтгэх алба болон удирдах зөвлөлийн ажил үүргийг тодорхой зааглан хуваарилсан болно. Холбооны удирдах зөвлөлийн гишүүний ажил үүрэг нь сайн дурын ажил бөгөөд ажилласан цаг үл харгалзан ямар нэгэн цалин урамшуулал авахгүй болно. Холбооны гүйцэтгэх албаны ажилтнууд томилолтын зардал авах эрхтэй.

Хэрэв Монгол-Германы эдийн засгийн хорооны хурал Германд зохион байгуулагдсан тохиолдолд удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх албаны төлөөллийн томилолтын зардлыг холбоо хариуцана.

Мэдээлэл дамжуулах

Холбооны гүйцэтгэх албаны ажилтнууд, удирдах зөвлөлийн гишүүд, гишүүн аж ахуйн нэгж, байгууллага, үйлчлүүлэгчид холбооны үйл ажиллагаанд өөрийн албан ёсны нэр, хаяг, холбоо утас зэргийг үнэн зөв мэдүүлэх үүргэтэй. Хэрэв өөрийн ажилтанаа холбооны үйл ажиллагаатай холбоотой уулзалт, хамтарсан арга хэмжээнд оролцуулах бол энэ талаар албан ёсоор илэрхийлсэн байна. Мөн холбооны лого, таних тэмдэг, албан бланк, захидал харилцааны тэмдэглэлийг зөвхөн холбооны үйл ажиллагааны хүрээнд ашиглана. Холбооны захидал илгээмжийг зөвхөн ГМБЭХ-ны гүйцэтгэх албаар дамжуулан явуулна.

Давхар алба эрхлэх

Холбооны гүйцэтгэх албаны ажилтан, удирдах зөвлөлийн гишүүн нь холбооны ажил үүргээс бусад хоёр дахь ажил үүрэг эрхэлсэн тохиолдолд энэ нь холбооны үйл ажиллагаа, эрх ашигт сөргөөр нөлөөлөхгүй байх ёстой.

Сонирхолын зөрчилийг шийдвэрлэх

Холбооны гишүүн, удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх албаны ажилтан нь ямар нэгэн сонирхолын зөрчил, үл ойлголцлоос зайлсхийх бөгөөд хэрэв ийм тохиолдолд холбооны эрх ашгийг хамгаалах үүднээс, зарчимаа баримтлан гүйцэтгэх захирал болон удирдах зөвлөлд мэдэгдэж, зөвлөгөө дэмжлэг авна.

Итгэл үнэмшил:

Мэдээллийг хамгаалах

Холбоо өөрийн ажилтан албан хаагч, байгууллагын болон гишүүн аж ахуйн нэгжүүдийн дотоод мэдээллийг 3 дахь этгээдэд дамжуулахыг хориглоно. Зөвхөн хуулийн хүрээнд эрх бүхий байгууллагын заавараар гүйцэтгэх захиралаар дамжуулан мэдээлэл хүргэж болно.

Хэвлэл мэдээлэл

Хэвлэлд мэдээлэл, олон нийтэд аливаа мэдээ мэдээлэл өгөхөөс өмнө тухайн мэдээллийн баталгаатай эх сурвалжаас авах, үнэн зөвийг нягтлах, нууцыг хамгаалах, мэдээлэл бүрийг гүйцэтгэх захирал хянах үүрэгтэй, хэрэв гүйцэтгэх захирал боломжгүй бол удирдах зөвлөлийг даргад мэдэгдэн нягтлуулж зөвшөөрөл авна. Гүйцэтгэх алба болон холбооны үйл ажиллагаатай хобоотой мэдээлэл бүрийг гүйцэтгэх захиралд дамжуулах ёстой.

Улс төрд хандах:

Улс төрийн төвийг сахисан байдал

Холбооны үйл ажиллагаа аливаа улс төрийн нам хүчний дэмжихгүй. Засгийн газар, төрийн захиргааны байгууллага, бусад холбоотой харилцах харилцаанд төвийг сахисан байр суурийг баримтлана. Холбооны Удирдах Зөвлөлийн гишүүн нь улс төрийн сонгуульд нэр дэвшихийг хориглоно.

Хамтран ажиллах тухай

Холбооны гишүүд, гүйцэтгэх албаны ажилтан, удирдах зөвлөлийн гишүүд нь аливаа арга хэмжээг зохион байгуулах, өдөр тутмын үйл ажиллагаандаа багаар ажиллах зарчимыг баримтлана.

Төгсгөлийн зохицуулалт:

Хэрэгжилт

Гүйцэтгэх захирал болон удирдах зөвлөлийн дарга энэхүү ёс зүйн дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргах, боловсронгуй болгох эрх үүрэгтэй.

Мэдээлэл өгөх

Энэхүү ёс дүрмийг зөрчсөн тохиолдолд гүйцэтгэх захирал, удирдах зөвлөлийн дарга, удирдах зөвлөлийн гишүүд тухайн асуудлыг шийдвэрлэж зөрчлийг арилгах талаар арга хэмжээ авах үүрэгтэй бөгөөд бүх гишүүдийн хуралд мэдээлэл хийнэ.

Зөрчил маргаан шийдвэрлэх

Энэхүү ёс зүйн дүрэмтэй холбоотой аливаа эргэлзээ, маргаан гарсан тохиолдолд эцсийн шийдвэрийг удирдах зөвлөл гаргах үүрэгтэй.

Хэрэв удирдах зөвлөлийн дарга эсхүл гишүүн ёс зүйн дүрэмтэй холбоотой зөрчил, маргаанд холбогдсон тохиолдолд бүх гишүүдийн хурлаар шийдвэрлүүлнэ. Гүйцэтгэх захирал нь сэжигтэй мэдээлэл, тохиолдлуудыг холбооны ашиг сонирхлын үүднээс тус ёс зүйн дүрэмийн дагуу шалган, нягтлаж ямар нэгэн шийдэл гаргах үүрэгтэй.

Хүчин төгөлдөр болох

Энэхүү ёс зүйн дүрэм нь ГМБЭХ-ны бүх гишүүдийн хурлаар батлагдаж батлагдсан өдрөөс хүчин төгөлдөр болно. Энэхүү ёс зүйн дүрэм нь Монгол улс болон Герман улсад хүчинтэй болно.

Улаанбаатар хот